МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 30 өдөр Дугаар А/182 Алтай хот

Сургалтын зардалд дэмжлэг
үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн худалдан авах ажиллагааг ил тод, шударга, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай зохион байгуулах мэдлэг ур чадварыг эзэмшүүлэх зорилгоор хавсралтад заасан нэр бүхий албан хаагчдыг төрийн худалдан авах ажиллагааны А3 гэрчилгээ олгох сургалтад хамруулж, зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 490,000 (дөрвөн зуун ерэн мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Алтанзагас)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ө.АМГАЛАНБААТАР

C:/My documents/-3A-4 doc

020[illegible]0600

Аймгийн Засаг даргын 2022 оны
03 дугаар сарын 30-ны өдрийн А/182 дугаар
захирамжийн хавсралт

СУРГАЛТАД ХАМРАГДАХ АЛБАН ХААГЧДЫН НЭРС

№	Овог нэр	Мэргэжил	Ажил байдал	Нийт
1	Золжаргал Жаргалтуяа	Эрчим хүчний инженер	Аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн	70,000
2	Жамъяндорж Мөнхчимэг	Барилгын инженер, архитектор	Аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн	70,000
3	Оросоо Золжаргал	Программист	Аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн	70,000
4	Арсланбаатар Доржготов	компьютер график дизайн	Инноваци, Бизнес Судалгаа Хөгжлийн Төвийн мэдээлэл технологи, инноваци хөгжүүлэлтийн албаны ахлах ажилтан	70,000
5	Энхболд Баатарсүрэн	Хэвлэлийн эх бэлтгэл, дизайн, хяналт	Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээлэл технологийн ажилтан	70,000
6	Бямбачулуун Цэрэндаваа	Барилгын инженер	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын хот байгуулалтын кадастр, зураг төсөл, магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн	70,000
7	Донойн Уган-Эрдэнэ	Замын инженер	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын зам хариуцсан инженер	70,000
Нийт дүн:				490,000

__oOo__